



## ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

### Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах журам батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.16 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн “Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтийг хангаж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл (М.Баяраа) болон Гүйцэтгэх захирал Б.Ганхуягт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.





## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫГ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай журам (цаашид “журам” гэх)-ын зорилго нь “Эрдэнэс-Тавантолгой” хувьцаат компани (цаашид “компани” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлах, хурлын мэдээллийг хүргэх, Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах болон хурлаар хэлэлцэх асуудал, хувьцаа эзэмшигчид хуралд оролцох, саналаа өгөх эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах үйл ажиллагаанд Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 162 тоот тогтоолоор баталсан “Компанийн засаглалын кодекс”, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “СЗХ” гэх)-ны 2018 оны 377 тоот тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам” “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн дүрэм, энэхүү журам болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актыг мөрдөж ажиллана.

### Хоёр. Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах

2.1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор зарлан хуралдуулна. Хэрэв энэхүү хугацаанд хуралдуулаагүй тохиолдолд Компанийн тухай хуульд заасан журмыг баримтлан Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулна.

2.2. Компанийн ээлжит бус хурлыг Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэг болон компанийн дүрэмд заасан үндэслэлээр Төлөөлөн удирдах зөвлөлөөс хэдийд ч зарлан хуралдуулж болно.

2.3. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэрт дараах зүйлийг тусгасан байна. Үүнд:

- 2.3.1. хурал хуралдуулах газар, өдөр, цаг;
- 2.3.2. хурлын хэлэлцэх асуудал;
- 2.3.3. хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэrsийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;
- 2.3.4. хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдөр, журам;
- 2.3.5. хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт;
- 2.3.6. саналын хуудсаар санал авах бол саналын хуудасны агуулга;
- 2.3.7. саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр;

- 2.3.8. хурлын дарга;
- 2.3.9. тооллогын комиссын дарга, гишүүд.
- 2.4. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гарсанаас хойш хурлын товд өөрчлөлт оруулахыг хориглоно.
- 2.5. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гарсанаас хойш 40-өөс доошгүй хоногийн дараа хуралдуулна.
- 2.6. Тухайн хурлаар хэлэлцэх асуудалтай шууд холбоотой компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийг тооллогын комиссын гишүүнээр томилохыг хориглоно.
- 2.7. Саналын эрх бүхий энгийн хувьцааны тав буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1-д заасан журмын дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудалд санал оруулах эрхийг эдэлнэ.
- 2.8. Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага нь энэхүү журмын 2.7-д заасны дагуу гаргасан саналыг хэлэлцэхдээ Компанийн тухай хуулийн 66 дугаар зүйлийг баримталж ажиллана.
- 2.9. Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-д заасан эрх бүхий этгээдээс зарласан Хувьцаа эзэмшигчдийн хурлын бэлтгэлийг хангахад компанийн удирдлага болон эрх бүхий албан тушаалтан дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээ мэдээллээр хангах үүрэгтэй.
- 2.10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулахтай холбогдсон зардлыг компани бүрэн хариуцна.
- 2.11. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах зорилгоор ажлын хэсэг байгуулж болно.
- ### **Гурав. Хурлын зар хүргэх**
- 3.1. Хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргүүлэхдээ СЗХ-ны 2018 оны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг мөрдөж ажиллана.
- 3.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гарсанаас хойш тав хоногийн дотор Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон компанийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчид хүргэх үүрэгтэй.
- 3.3. Энэ журмын 3.2-т заасан мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлнэ.
- 3.4. Хурлын зарыг энэ журмын 3.2-т зааснаас гадна утас, факс, электрон шуудан, албан бичиг зэрэг харилцаа холбооны боломжит бусад хэрэгслийг ашиглан хувьцаа эзэмшигчид хүргэж болно.

3.5. СЗХ-ны 2018 оны “Хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2.6, 2.7-д заасан мэдэгдлийг хурал хуралдуулах шийдвэр гарсанаас хойш 3 хоногийн дотор СЗХ болон шаардлагатай тохиолдолд арилжаа эрхлэх байгууллагад тус тус хүргүүлнэ.

3.6. Хурлын зард СЗХ-ны 2018 оны “Хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 3.7-д заасан мэдээллийг тусгана.

### **Дөрөв. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох**

4.1. Хувьцаа эзэмшигч нь Хувьцаа эзэмшигчдийн хуралд өөрийн биеэр буюу Иргэний хуульд заасны дагуу бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр өөр этгээдээр төлөөлүүлэн оролцож болно.

4.2. Энэ журмын 4.1-д заасны дагуу итгэмжлэлийн үндсэн дээр хуралд оролцож байгаа итгэмжлэгдсэн төлөөлөгч нь энэ тухайгаа хурлын бүртгэл явагдаж байх үед Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга болон тооллогын комиссын даргад мэдэгдсэн байна. Энэхүү итгэмжлэл нь зөвхөн тухайн хуралдаа хүчинтэй болно.

4.3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцохтой холбоотой энэхүү журмаар зохицуулаагүй харилцааг зохицуулахдаа Компанийн тухай хуулийн 68 дугаар зүйлийг баримтлана.

### **Тав. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал**

5.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.

5.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит болон ээлжит бус байна.

5.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д болон компанийн дүрэмд Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулахаар заасан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

5.4. Дараах асуудлыг зөвхөн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ:

5.4.1. компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;

5.4.2. нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;

5.4.3. компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;

5.4.4. компанийн хэлбэрийг өөрчлөх;

5.4.5. компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;

5.4.6. хувьцааг хуваах буюу нэгтгэх;

5.4.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;

- 5.4.8. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
- 5.4.9. Төлөөлөн удирдах зөвлөлөөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Компанийн тухай хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцэл болон мөн хуулийн арванхоёрдугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;
- 5.4.10. Хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдаж авах эрхээ хэрэгжүүлэх эсэх;
- 5.4.11. Компанийн тухай хуульд заасны дагуу компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрөх;
- 5.4.12 Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;
- 5.4.13. Хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудал.

### **Зургаа. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах**

6.1. Хурлыг компанийн ерөнхий захиргаа байрлаж байгаа газраас өөр газарт хуралдуулахаар товлосон бол хуралд оролцох эрх бүхий Хувьцаа эзэмшигчдийн аль болох төвлөрсөн, аливаа зардал чирэгдэл багатайгаар оролцох боломжтой газарт хурлыг хуралдуулна.

6.2. Хурал зохион байгуулах комисс нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын явцад уг хуралд оролцогч бүх хувьцаа эзэмшигч санал бодлоо илэрхийлж, өөрийн сонирхсон асуултаа тавьж, зохих хариултаа авах боломжийг бүрдүүлсэн байна.

6.3. Хурлыг ажлын болон ажлын бус өдрүүдийн 08.00 цагаас 22.00 цагийн хооронд зохион байгуулна.

6.4. Холбогдох хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол компанийн нэг хувьцаа нэг саналын эрхтэй байж, саналын эрхтэй хувьцаа эзэмшигч нь санал хураалтаар шийдвэрлэх асуудал бүрээр санал өгнө. Кумулятив аргаар санал хураахад энэ заалт хамаarahгүй.

6.5. Хурлыг зохион байгуулах комисс хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг зохих бүртгэлийг үндэслэн холбогдох бичиг баримтыг шалгах замаар саналын хуудсаар санал авах танхимд оруулна.

6.6. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь хэлэлцэх асуудалд ороогүй асуудлыг хэлэлцэхийг хориглоно.

6.7. Тооллогын комисс нь хуралд дараах эрх, үүрэгтэйгээр оролцоно. Үүнд:

6.7.1. Тухайн хуралд саналын хуудсаар саналаа урьдчилан өгсөн болон биеэр оролцохоор ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн ирцийг тогтоож, хурлын даргад мэдээлэх;

6.7.2. Тооллогын комисс санал өгөх журмыг хуралд оролцогчдод дэлгэрэнгүй танилцуулах ба саналын хуудсыг хэрхэн бөглөх буюу саналаа өгөх, ямар тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн өгсөн санал, саналын хуудас хүчингүй болох талаар нэг бүрчлэн тайлбарлах (Хэрэв хувьцаа эзэмшигч санал хураах нэг асуудал дээр санал өгөхдөө 1-ээс илүү хариулт сонгосон, хариултыг сонгоогүй тохиолдолд зөвхөн тэр асуудал дээр өгсөн санал хүчингүйд тооцогдоно. Хувьцаа эзэмшигч нь саналын хуудасны дээр санал өгөхдөө санал өгөх тусгайлан заасан хоосон зайд тэмдэглэгээ үйлдэх ба хэрэв үүнээс өөрөөр ямар нэгэн байдлаар саналын хуудсанд тэмдэглэгээ хийвэл саналын хуудас бүхэлдээ хүчингүйд тооцогдоно. Хэрэв санамсаргүй, болгоомжгүй болон бусад байдлаар саналын хуудсанд тэмдэглэгээ хийсэн тохиолдолд хурлын комисс болон тооллогын комисст энэ талаар мэдэгдэн, саналын хуудсаа хураалган, шинээр саналын хуудас авч болно).

6.8. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг кумулятив арга (энгийн хувьцаа тус бүр сонгогдох гишүүдийн тоотой тэнцэх саналын эрхтэй байх бөгөөд хувьцаа эзэмшигч нь өөрийн хувьцаанд ногдох саналаа бүгдийг нь нэг хүнд, эсхүл хэд хэдэн хүнд хуваан өгөх эрхтэй)-аар сонгоно.

6.9. Санал авах хуудас нь Компанийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

6.10. Хэрэв хуралд оролцогч этгээд нь итгэмжлэлийн үндсэн дээр санал өгсөн бол саналын хуудсаа тооллогын комисст өгөхдөө холбогдох итгэмжлэлийг хавсаргана.

6.11. Тооллогын комисс саналыг тоолон, санал хураалтын үр дүнг нэгтгэн дүгнэж, дүнгийн тухай шийдвэр гаргана. Уг шийдвэрт тооллогын комиссын дарга гарын үсэг зурж, шийдвэрийн үнэн зөвийг хариуцна.

6.12. Тооллогын комиссын дарга нь гаргасан шийдвэрээ Хувьцаа эзэмшигчдийн хурлыг даргалагчид өргөн барина.

6.13. Тухайн Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга хурлаас гарсан шийдвэрт гарын үсэг зурж, компанийн тамгыг дарж баталгаажуулна.

6.14. Компани нь хурлын шийдвэрийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8, 56 дугаар зүйлийн 56.1.6-д заасны дагуу нэн даруй нийтэд мэдээлж, СЗХ-ны 2018 оны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зар хүргэх журам”-ын 2.10-д заасан холбогдох бичиг баримт, мэдээллийг хуульд заасан хугацаа буюу хурал хуралдсанаас хойш ажлын 3 өдрийн дотор Хороо болон шаардлагатай тохиолдолд арилжаа эрхлэх байгууллагад тус тус хүргүүлнэ.

### **Долоо. Хурал хүчин төгөлдөр болох**

7.1. Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно.

7.2. Энэ журмын 7.1-д заасан хувь хүрээгүй бол хурлыг хойшлуулж, дахин хуралдах өдрийг Төлөөлөн удирдах зөвлөл товлох бөгөөд энэ тохиолдолд хойшлогдсон хурлаар хэлэлцэх асуудлыг өөрчлөхийг хориглоно.

7.3. Энэ журмын 7.2-т заасны дагуу хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурлыг ажлын 20 өдрийн дотор хуралдуулах бөгөөд уг хурал хуралдахаас ажлын ажлын 7-оос доошгүй өдрийн өмнө хувьцаа эзэмшигчдийн хурал болох газар, өдөр, цагийг дахин мэдээлнэ.

7.4. Хойшлогдсон хурлыг зохион байгуулах, хурлын ирцийг тогтоохдоо Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

### **Найм. Хариуцлага**

8.1. Журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгүүлэхээр эрх бүхий байгууллагад асуудлыг тавьж болно.

8.2. Журмыг зөрчсөн холбогдох ажилтан, албан тушаалтны үйлдэлд эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэхээргүй бол Компанийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”-д заасны дагуу холбогдох хариуцлагыг ногдуулна.

8.3. Журмыг зөрчсөн ажилтан, албан тушаалтны үйлдэл нь компанийн эд хөрөнгөд хохирол учруулсан бол түүнд сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ.

-----ooOoo-----